



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/143

Мандалговь

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой
микробиологийн аргаар тэмцэх ажлыг
зохион байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Бэлчээр хамгаалах өдөр 185 дугаар тогтоол, Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Сайнцагаан, Цагаандэлгэр, Эрдэнэдалай зэрэг 7 сумын 10,0 мянган га бэлчээрийн талбайд бактержуулсан бэлдмэлээр 2023 оны 04 дүгээр сарын 13-27-ны өдрийн хооронд 14 хоногийн хугацаанд багтаан явуулсугай.

2. Тухайн ажлыг зохион байгуулахдаа “Бэлчээр хамгаалах өдөр”-тэй холбогдуулан сум бүр орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, мэргэжлийн анги албад, албан байгууллага, иргэдийг оролцуулан гүйцэтгүүлж, бэлчээрт үр дүнтэй ажил зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн анги албад, албан байгууллага, иргэд, малчдыг оролцуулан, хөдөлмөр хамгааллын хувцас, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлж ажиллах, уг арга хэмжээнд шаардагдах зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс гаргахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. 2023 онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх сумдын нэр, бэлдмэлийн хэмжээ, тэмцэх талбайг хавсралтаар баталсугай.

5. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэд хяналт тавих, ажлын явцад байнгын хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.АНХБАЯР



4823100577

Аймгийн Засаг даргын орлогчийн *2025* оны
04...дүгээр сарын *13*-ны өдрийн
А.П.В. дугаар захирамжийн хавсралт

Микробиологийн аргаар тэмцэх сумд, бэлдмэлийн хэмжээ, тэмцэх талбай

Д/д	Сумдын нэр	Бэлдмэлийн хэмжээ /тн/	Тэмцэх талбайн хэмжээ мянган/га
1	Адаацаг	4	2
2	Говь-Угтаал	3	1,5
3	Дэрэн	3	1,5
4	Дэлгэрцогт	3	1,5
5	Сайнцагаан	1	0,5
6	Цагаандэлгэр	3	1,5
7	Эрдэнэдалай	3	1,5
	Нийт дүн	20	10